



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/195

Ховд

Байгууллага, албан хаагчдыг дайчлан
ажиллуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "б" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06.00 цагаас эхлэн шилжсэнтэй холбогдуулан 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд Жаргалант сумын хэмжээнд хөл хорио тогтоох, хяналт тавих ажиллагаанд тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага /Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар- 20, Цагдаагийн газар- 40, Дотоод хэргийн их сургуулийн сонсогч-41, Зэвсэгт хүчний 123 дугаар анги-60, Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги-20/, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг-120, Улаан загалмайн хороо-15, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн албан хаагчдыг дайчлан ажиллуулсугай.

2. Дайчилгаанд ажиллах албан хаагчдад Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс батлагдсан хүн нэг бүрт байх аранзны бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ажиллахыг тусгай чиг үүргийн байгууллага, Боловсрол, соёл, урлагийн газар, Улаан загалмайн хороо, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдлагууд, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

2021.04.09
02 1112